



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

«Хан-Уул дүүргийн 243 дугаар цэцэрлэгийн  
хөрөнгийг данснаас дансанд  
шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бараа материалын дансанд бүртгэлтэй нийт 3,876,500 (гурван сая найман зуун далан зургаан мянга таван зуу) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэхийг Хан-Уул дүүргийн 243 дугаар цэцэрлэг (В.Алтангэрэл)-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 243 дугаар цэцэрлэг (В.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ч.САЙХАНБАЯР

D:\НӨХГТ\тушаал 2023\А тушаал.docx

1150500049

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2023 оны .04. дүгээр сарын ..25. -ны өдрийн  
1/37 дугаар тушаалын хавсралт



**Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

Байгууллага: Хан-Уул дүүргийн 243 дугаар цэцэрлэг

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Бүртгэх анхны		Дансны нэр	
						Нэгжийн үнэ	Нийт үнэ	Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Булангийн тавиур	2022	сайн	ш	1	100,000.00	100,000.00	бараа материал	үндсэн хөрөнгө
2	Вандан сандал	2019	сайн	ш	1	700,000.00	700,000.00	бараа материал	үндсэн хөрөнгө
3	Тавиур	2020	сайн	ш	1	300,000.00	300,000.00	бараа материал	үндсэн хөрөнгө
4	Тоглоомын тавиур	2021	сайн	ш	1	716,500.00	716,500.00	бараа материал	үндсэн хөрөнгө
5	Чийрэгжүүлэгч	2018	сайн	ш	1	760,000.00	760,000.00	бараа материал	үндсэн хөрөнгө
6	Шат	2019	сайн	ш	1	1,300,000.00	1,300,000.00	бараа материал	үндсэн хөрөнгө
Тавилга эд хогшлын дүн							3,876,500.00		
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн							<b>3,876,500.00</b>		